

Олон Улсын Театрын Институт

Гүйцэтгэн тоглох урлагийн дэлхийн байгууллага



2023 оны 3 дугаар сарын 27 Дэлхийн Театрын Өдөрт зориулсан захидал

Захидал илгээгч: Самиха Аёоб, Египет
Египетийн жүжигчин

Монгол (Орчуулга)

Дэлхийн Театрын Өдөр 2023-д зориулсан Самиха Аёобын Захидал

Дэлхий дахинаа тархан суугаа бүх найз нөхөд, театрын уран бүтээлчдэд,

Дэлхийн Театрын Өдрөөр би та бүхэнд хандан энэ захидлыг бичиж байгаа бөгөөд та бүгдтэй ярьж байхдаа би маш их аз жаргалыг мэдрэхийн сацуу бидний өнөөгийн дэлхий дахины нөхцөл байдлаас үүдэх асар хүчтэй дарамт, өөрт төрж буй янз бүрийн мэдрэмжүүд, ялангуяа театрын болон театрын бус уран бүтээлчид бид бүгдийн туулж буй зовлон шаналлын хүнд ачааг мэдрэх бүр биеийн минь эд эс бүхэн дагжин чичирч байна. Тогтворгүй байдал бол бидний өнөөгийн дэлхий нийтээрээ даван туулж буй зүйлсийн шууд үр дагавар, тухайлбал зөрчил мөргөлдөөн, дайн болон байгалийн гамшигт үзэгдлүүд бидний материаллаг ертөнцөд төдийгүй оюун санааны ертөнц хийгээд сэтгэл зүйн амар амгалан байдалд сөргөөр нөлөөлж аймшигт үр дагаварт хүргэж байна.

Би өнөөдөр та бүгдтэй ярихдаа дэлхий ертөнц бүхэлдээ тусгаарлагдмал арлууд мэт, үгүй бол манан бүрхсэн тэнгэрийн хаяанд тус бүр ямар ч чиглүүлэгчгүй далбаагаа дэлгэн ийш тийш тархан зугтах мэт агаад удирдан залж буй зүйл нь огт харагдахгүй ч давлагаалан архирах их далайд урт удаан тэнүүчилсний эцэст аюулгүй газарт хүрнэ гэсэн итгэл тээн үргэлжлүүлэн хөвсөөр буй хөлөг онгоцнууд мэт байдлыг сэтгэлдээ мэдэрч байна.

Бидний дэлхий урьд өмнө байгаагүйгээр бие биетэйгээ илүү ойр холбогдсон ч гэлээ нэгэн зэрэг хэзээ ч ингэж өнөөдрийнх шиг бид нэг нэгнээсээ холдон алдагдаж байгаагүй юм. Манай орчин үеийн дэлхий ертөнцийн бидэнд тулгаж буй гайхалтай парадокс энд л оршин байна. Бид газар зүйн хил хязгаарыг эвдсэн мэдээллийн, орчин үеийн харилцаа холбооны эргэлтийн гэрч болсон хэдий ч зөрчил мөргөлдөөн болон хурцадмал байдал нь бидний ертөнц бүхэлдээ логик ойлголтынхоо хязгаарыг давж, хүн төрөлхтний жинхэнэ мөн чанараас биднийг хамгийн энгийн хэлбэрээр үндсээр нь гажуудуулж буйг гэрчилж байна.

Театр бол уг чанараараа хүн төрөлхтний жинхэнэ мөн чанар буюу амьдралд үндэслэсэн цэвэр хүний үйлдэл юм. Аугаа анхдагч Константин Станиславскийн хэлснээр, “Театрт шавхайтай гуталтай хэзээ ч бүү ир. Тоос шороо, хир бургтаа гадна үлдээ. Хувцаслалттай

холбоотой бяцхан санаа зовнил, хэрүүл маргаан, аахар шаахар асуудлаа – амьдралыг тань сүйрүүлж буй бүхий л зүйлсийг болон анхаарлыг тань урлагаас хөндийрүүлж буй болгоныг шалга – бүгдийг нь үүдэнд орхи.” Бид тайзнаа гарахдаа бидний дотор орших цор ганц амьдрал болох тэр цор ганц хүнээр тайзнаа гардаг, гэхдээ тэр амьдрал хуваагдаж бас олон амьдралыг бий болгон өсөн үржих аугаа чадвартай ба үүнийг л бид дэлхий дахинд үзүүлж, эндээс л амьдрал бий болж цэцэглэн хөгжиж, тансаг үнэр нь бусдад тархаж байдаг юм.

Жүжгийн зохиолч, найруулагч, жүжигчин, тайзны зураач, яруу найрагч, хөгжимчин, бүжигчин болон техникийн ажилтнууд гээд театрын ертөнц дэх бидний хийдэг ажил ганцхан зүйлд л төвлөрдөг, тэр нь хэзээ ч байгаагүй амьдралыг тайзнаа амьдруулж бүтээх үйл. Энэ амьдрал нь тосоод барьж авах халуун гар, тэврэн авах хайр, ойлгон хайрлах зүрх, бас цаашид амьдрах шалтгааныг бий болгодог саруул ухааныг хүртэх эрхтэй.

Тайзан дээр бид оргүй хоосноос амьдрал бий болгодог гэдгийг би хэтрүүлэн хэлж байгаа юм биш, энэ бол тас харанхуйд гялалзах шатаж буй цог, харанхуй шөнийг гэрэлтүүлэх гэрэл болон хүйтнийг үгүй хийх халуун илч мэт юм. Бид бол амьдралд цог жавхаа бэлэглэгчид. Үүнийг бид өөртөө агуулж байдаг. Бид амьдралыг илүү амьд бас утга учиртай болгогчид. Мөн бид амьдралыг ойлгох учир шалтгааныг бий болгогчид юм. Мунхгийн харанхуй болон хэт туйлшралын эсрэг урлагийн гэрлийг ашигладаг хүмүүс бол бид. Бид амьдралын сургаалыг хүлээн авч, дэлхий ертөнцөд амьдрал түгээх үүрэгтэй хүмүүс. Ийм учраас бид цаг наргүй хичээн зүтгэж хөлсөө урсган эд эс бүхнээ зориулдаг агаад үнэн, сайн сайхан хийгээд гоо үзэсгэлэнгийн үнэ цэнийг хамгаалж, амьдрал амьдрах ёстой гэдэгт чин үнэнээр итгэн энэхүү эрхэм нандин захиасыг биелүүлэхийн төлөө бид бүхнийг хийх ёстой хүмүүс.

Би өнөөдөр та бүхэнтэй ярьж гэж зүгээр нэг ярьж буй хэрэг биш, тэр бүү хэл бүхий л урлагийн эцэг болох “театрын” урлагийг тэмдэглэх энэ өдөр ярьж байгаа юм биш. Харин эсрэгээрээ би та бүхнийг хамтдаа зогсож, гар гараасаа атган мөр зэрэгцэн зогсоод хоолой мэдэн уриалаач гэж урьж байна. Ярьж сурсан тайзаа ашиглан одоо хэлэх үг тань бүх дэлхийн ухамсрыг сэргээж, хүн төрөлхтний алдагдсан мөн чанарыг дотроосоо хайхыг уриалан дуудах хүчтэй байг. Эрх чөлөөт, хайрлан өрөвдөх сэтгэлтэй, эелдэг зөөлөн, хүнлэг хүн байхыг. Харгислал, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, цуст мөргөлдөөн, нэг талыг барьсан явцуу сэтгэлгээ, хэт туйлширсан үзлийг та бүгд таягдан хаяцгааг. Хүн төрөлхтөн олон мянган жилийн турш энэ дэлхий дээр, энэ тэнгэрийн дор алхдаг байсан, цаашид ч үл мөрөө үлдээн алхсаар байх болно. Тиймээс дайн, цуст мөргөлдөөний шавар шавхайгаас хөлөө татаж, тайзны гадна үлдээгээрэй. Ингэснээр эргэлзэн төөрөлдсөн бидний хүн төрөлхтөн дахин сэргэж бид бүгдээрээ хүн төрөлхтөн, үүгээрээ та бид бүгд ахан дүүс гэдгээрээ үнэн сэтгэлээс бахархах чадвартай болж магадгүй юм.

Гэгээрлийн бамбарыг баригчид болох жүжгийн зохиолчид бидний эрхэм зорилго бол анхны тайзнаа гараагаа эхэлж буй жүжигчин эхнээсээ дуусах хүртлээ хүнлэг бус, муу муухай, цуст аливаа бүхнийг илчлэн харуулж ойлгуулах явдал юм. Ингэхдээ бид цэвэр ариун, үлэмжийн сайхан, бас хүнлэг бүхнээр илчилж ойлгуулна. Биднээс өөр хэнд ч амьдралыг

түгээх чадвар байхгүй. Нэгдмэл нэг дэлхий, нэг хүн төрөлхтний төлөө хамтдаа амьдрал түгээцгээе.

Самиха Аёоб

Орчуулсан: Наянбаатарын Болороо, Монгол/ОУТИ-ийн Монгол төв